



# СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№152 /366/

2022.08.26

## Цаг үе, үйл явдал

### АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА НАРТАЙ ХАМТАРСАН ЦЭРЭГ-СТРАТЕГИЙН БЭЛТГЭЛ СУРГАЛТ БОЛЛОО

Өнөөдөр Аймаг, нийслэлийн Засаг дарга нарын Цэрэг-стратегийн бэлтгэл сургалтыг Батлан хамгаалах яамнаа зохион байгууллаа. Энэхүү сургалтад Монгол Улсын Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, дэд сайд Б.Баярмагнай, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуяг, ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг нарын батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний удирдлагууд болон аймаг, хийслэлийн Засаг дарга нар оролцсон юм. Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр сургалтыг нээж хэлсэн үгэндээ “Шинэ Засгийн



газар байгуулагдсанаас хойш Дайчилгааны тухай хууль, Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтарсан цэрэг-стратегийн сургалтыг анх удаа зохион байгуулж байна.

Дэлхийн улс орнуудын цэрэг улс төрийн байдал эмзэг, мэдрэмтгий байгаа нь манай улс орны эдийн засаг, иргэдийн зорчих хөдөлгөөн гэх мэт асуудалд ч нөлөөлж байгаа учир энэ удаагийн сургалтаар

цэрэгжилт-спортын “ДӨЛ-2022” улсын аварга шалгаруулах тэмцээнд хурд хүч, авхаалж самбаа, оюун ухаанаа уралдуулж, өрсөлдөөн ч байгаа талаар дуулгаад, хүүхэд, залууст цэрэг-эх оронч хүмүүжил төлөвшүүлэх, бие бялдрын болон

Зэвсэгт хүчин, Хил хамгаалах байгууллагатай холбоотой асуудлуудыг хөндөж, мэдээллээр хангаж ажиллана” гэв. Мөн тэрбээр эдгээр өдрүүдэд 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн шилдэг хүүхэд залуусын төлөөлөл Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдаж буй

ёс суртахуун, сэтгэл зүйн хүмүүжил олгох, эх орноо батлан хамгаалах бэлтгэл эзэмшүүлэх өндөр ач холбогдолтой энэхүү тэмцээнд БШУЯ, ЕБС-иуд, аймаг, нийслэлийн орон нутгийн удирдлагуудыг зохион байгуулалтын өндөр түвшинд хамтарч ажиллаж байгаад талархлаа илэрхийллээ.

Орон нутгийн удирдлагууд маргааш Зэвсэгт хүчний нэгдсэн сургалтын төвд зочилж, “ДӨЛ-2022” улсын аварга шалгаруулах тэмцээний хаалтын үйл ажиллагааг үзэж сонирхохын зэрэгцээ Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч У.Хүрэлсүх болон тэмцээний оролцогч хүүхэд залуучуудын хамтаар “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарих юм.

### ЭРХЭМ ХУРАНДАА АНГИЙН ТУГАНДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



“Цэрэг хаана-Бид тэнд” уриатай Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн бие бүрэлдэхүүн өнөөдөр цэргийн тангарагаа давтан, төрийн дууллаа эгшиглүүлж, байлдааны тугаа ёслол төгөлдөр залж, хүндэтгэл дүүрэн жагссан нь ангийн захирагчаар олон жил, үр бүтээлтэй ажилласан эрхэм хурандаа Б.Батбаатар байлдааны тугандаа хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагааны эхлэл байлаа.

1987 онд Их говийн гарнизон Зүүнбаянгаас ажил амьдралын гараагаа эхэлж, Зэвсэгт хүчин хэмээх их айлын нэгэн гишүүн болсноос хойш 30 гаруй жилийн хугацаанд Материал хангалтын бааз, АТГ, Хуурай замын цэргийн командлал, БХЯ, ЗХЖШ-ын

Үйлчилгээ аж ахуйн хэлтэс, Бөртэ болон Баянбаян ТӨУҮГ зэрэг батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчинд удирдах албан тушаалуудад ажиллаж байгаад Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн захирагчаар томилогдон ажилласан эрхэм хурандаа Б.Батбаатар ангийнхаа ар талын бэлэн байдлыг дээшлүүлэх, материал хэрэгслийн хангалтын чанар үйлчилгээнд онцгойлон анхаарч ажиллаж ирсэн билээ.

Ангийн захирагч хурандаа Н.Бат-Эрдэнэ, бэлтгэл хурандаа Б.Батбаатарын цаашдынх нь ажил амьдралд амжилт хүсэж, ангийн ахмад настны бүртгэлд бүртгэсэн гэрчилгээ, дурсгалын зүйл гардуулсан юм.

## ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 14	☁️ 2

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 29	☁️ 21

## ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.215	3.220
EUR 🇪🇺	3.235	3.250
CNY 🇨🇳	471	473
RUB 🇷🇺	50	50.30
JPY 🇯🇵	23.60	23.75
KRW 🇰🇷	2.41	2.43

## ЗУРХАЙ



2022.08.26 /БААСАН ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 29

**ЗУНЫ АДАГ УЛААГЧИН ХОНЬ САРЫН НАЙМАН ЦАГААН ЦАГААГЧИН ӨДӨР**

**Үс засуулбал:**

Сүлд тэнэж одно

**НАРАН УРГАХ, ШИНГЭХ:** 06.02-19.46

**Барилдлага:**

Идэр

**Шүтэн барилдлага:**

Нэр өнгө

**Суудал:** Огторгуй

Энэ өдөр хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай, жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй.

Эл өдөр эе эвээ ололцох, хамтын хөдөлмөр эрхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх авах, үнэт эрдэнийн зүйл авах сайн. Газар ухах, худаг, гаргах, сэтгэлд очиход хийхэд муу.

Хол газраар яваар одогсод зүүн хойд зүгт мөрөө гаргавал зохистой.

## КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 604,393,816

Эдгэрсэн

Нийт: 579,247,153

Нас барсан

Нийт: 6,483,270

Цаг үе, үйл явдал

# ЖАГСААЛ БОЛОН ГАРДАН ТУЛААНЫ ҮЗҮҮЛЭХ ТОГЛОЛТ ЯВАГДАЖ БАЙНА



Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдаж байгаа Батлан хамгаалахын сайдын нэрэмжит улсын аварга шалгаруулах “Дөл-2022” цэрэг-спортын цогцолбор тэмцээн үргэлжилж байна.

Тэмцээний төлөвлөгөөний дагуу 8 дугаар сарын 26-ны өдөр гардан тулаан болон жагсаалын үзүүлэх тоглолт болж байна. 21 аймаг, 9 дүүргийн шилдэг тасгууд сугалааны гарааны дагуу жагсаалын үзүүлэх тоглолтоо шалгуулж, үргэлжлүүлэн гардан тулааны үзүүлэх тоглолтоо шүүгч, бусад оролцогч нөхдийнхөө өмнө толилуулж байна.

Жагсаалын үзүүлэх тоглолтоор тасгууд

зэвсэггүй жагсах үеийн жагсаалын ажиллагаа, хөдөлгөөн, ёсолж хүндэтгэх, жагсаалаас гарах, жагсаалд орох, захирагчид илтгэх, буцах ажиллагааг дүрмээр нь гүйцэтгэж, тасгийн жагсаалын жигдрэлт, жагсаалын удирдах дохио, жагсаалын дууг толилуулж байна.

Ингэхдээ цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээний сүлд дууг заавал сурсан байхаас гадна жагсаалын 10 дуунаас нэгийг нь сугалж, жагсаалаар алхах явцдаа дуулж байна.

Харин гардан тулааны үзүүлэх тоглолтоор зэвсэггүй гардан тулааны хөдөлгөөнүүд, катанууд, зэвсэгтэй гардан тулааны дасгал, хөдөлгөөн, ката-



нууд, гарын цохилт, хөлийн өшиглөлтийн техникийн үзүүлэлтүүд, түүний уялдаа зохиомж зэргийг нь шүүгч нар голчлон анхаарч байгаа ажээ.

Жагсаалын үзүүлэх тоглолтын ахлах шүүгчээр Зэвсэгт хүчний 345 дугаар нэгтгэлийн захирагч, хурандаа Б.Хаш-Эрдэнэ, шүүгчээр Батлан хамгаалах яамны Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн, дэд хурандаа Б.Ширнэн, гардан тулааны үзүүлэх тоглолтын ахлах шүүгчээр тэмцээний Ерөнхий шүүгч, ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрын Биеийн тамир, спортын тасгийн дарга, Монгол Улсын гавьяат дасгалжуулагч, хурандаа Д.Цог-Эрдэнэ, шүүгчээр

Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн Биеийн тамир, спортын офицер, ахлах дэслэгч Х.Гантулга нар ажиллаж байна.

Гарааны сугалаа ёсоор Булган 1, Завхан 2, Архангай 3, Өвөрхангай 4, Дорнод 5, Хөвсгөл 6, Дорноговь 7, Өмнөговь 8, Сэлэнгэ 9, Хэнтий 10, Дундговь 11, Сүхбаатар аймаг 12, Төв 13, Ховд 14, Баянгол дүүрэг 15, Увс 16, Налайх дүүрэг 17, Говь-Алтай 18, Дархан-Уул 19, Говьсүмбэр 20, Багануур дүүрэг 21, Баян-Өлгий 22, Чингэлтэй дүүрэг 23, Сүхбаатар дүүрэг 24, Баянхонгор 25, Орхон 26, Баянзүрх дүүрэг 27, Хан-Уул дүүрэг 28, Сонгинохайрхан дүүрэг 29 дүгээрт даалгавруудаа гүйцэтгэж байгаа юм.

Ахлах дэслэгч Д.Болор



Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХУЯГ



ЦАХИМ ХАЯГ



Батлан хамгаалах яам



Зэвсэгт хүчний Жанжин штаб



ЦАХИМ ХУУДАС



“Соёмбо” сонин



“Дуулга” студи

\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.

\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.

\* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018

Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn Утас: 70001029, 3412 (дотуур)